

“ХӨНГӨН БЕТОН”ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 05-р сарын 01-ны өдөр

№ 04

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн хойшлогдсон хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 69.1, 69.3, 69.6, 69.9 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Хөнгөн бетон” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хойшлогдсон ээлжит хурлыг 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 16.00 цагт Улаанбаатар хотод цахим хэлбэрээр зарлан хуралдуулсугай.

3. Хувьцаа эзэмшигчдийн хойшлогдсон ээлжит хурал хуралдуулах тухай шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн биржид хүргүүлэх, хурлын зар мэдээг Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-д заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх арга хэмжээ авахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Ундрахад даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  Б.НАРАНЗУЛ



“ХӨНГӨН БЕТОН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ИРЦИЙН ТЭМДЭГЛЭЛ

2020.04.30

Улаанбаатар хот

“Хөнгөн бетон” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцаа 177,154 ширхэг байгаа. Үүнд:

Д/д	Хувьцаа эзэмшигчдийн нэрс	Тоо ширхэг	Хувь
1	Б.Наранзул	57,399	32,4%
2	Н.Эрдэмбилэг	53,842	30,3%
3	Б.Наранцацралт	26,655	15%
4	Н.Эрдэмбаяр	23,306	12,99%
5	“Минжит булган гол” ХХК	14,918	8,4%
6	Т.Баярхүү	1,034	0,5%

“Хөнгөн бетон” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 15:00 цагт цахим хэлбэрээр буюу Zoom app- аар холбогдож хурлыг явуулах болсон боловч хурал эхлэх үед бүртгэхэд “Хөнгөн бетон” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд саналын эрхтэй 77,148 ширхэг хувьцаа буюу нийт саналын эрхтэй хувьцааны 43 хувийг төлөөлсөн 2 хувьцаа эзэмшигч болох Н.Эрдэмбилэг, Н.Эрдэмбаяр /итгэмжлэгдсэн төлөөлөгч А.Номинзул-итгэмжлэлтэй/ цахимаар хийх хуралд оролцоход бэлэн гэж мэдэгдсэн бөгөөд бусад хувьцаа эзэмшигчид буюу Б.Наранзул, Б.Наранцацралт, Т.Баярхүү нар нь хуралд оролцож амжихгүй болсоноо мэдэгдсэн.

Иймд “Компанийн тухай хууль”-ийн 69.1 дэх заалт, Компанийн дүрмийн 4.24 дэх заалтыг үндэслэн хурлын ирц хүрээгүй тул хурал хойшилсон болно.

- Хойшлогдсон хурлын товыг тогтоож, КТХ-ийн 69.9-д заасантай нийцүүлэн ажлын 20 хоногийн дотор хуралдуулах бөгөөд хурал хуралдахаас ажлын 7-оос доошгүй хоногийн өмнө хойшлогдсон хурлын зарыг нийтэд дахин мэдээлнэ
- Хурал хойшлогдсон тухай мэдэгдлийг СЗХ болон МХБ-д ажлын 4 хоногт багтаан тус тус хүргүүлнэ.

Тэмдэглэл хөтөлсөн: ТУЗ-ийн нарийн бичиг



Б.Ундрах